



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 10 өдөр

Дугаар А/03

Хэрлэн сум

“Өсвөр үеийн шигшээ баг”-ийн спортын
нэр төрлийг тогтоож, зардал олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1, 60.1.21, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.2.3, Биеийн тамир спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.1.1, 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 06 дугаар тогтоол, 2017 оны “Журам батлах тухай” 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор “Өсвөр үеийн шигшээ баг”-ийн тамирчдын 2023 оны төсвийн хуваарийг нэгдүгээр хавсралтаар, дасгалжуулагчийн цалингийн төсвийг хоёрдугаар хавсралтаар, спортын нэр төрөл, тоог гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Дээрх зардалд шаардагдах 150,000,000 (нэг зуун тавин сая) төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-т, гүйцэтгэлийг зохион байгуулж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д тус тус даалгасугай.

3.Өсвөр үеийн шигшээ багийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар ханган, хичээл сургуулилт, ажлын үр дүнг улирал бүр тооцон хагас, бүтэн жилээр тайлагнан ажиллахыг Биеийн тамир, спортын газар (Г.Нэргүйбаатар)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч бөгөөд Өсвөр үеийн шигшээ багийн үйл ажиллагааг зохицуулах зөвлөлийн дарга (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Хэнтий аймгийн Өсвөр үеийн шигшээ багийн 2023 оны төсвийн хуваарь

№	Жилийн төсөв	Жилийн төсөв	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар
1	Цалин	108,960,000	9,080,000	9,080,000	9,080,000	9,080,000	9,080,000	9,080,000	9,080,000	9,080,000	9,080,000	9,080,000	9,080,000	9,080,000
2	НДШ	13,620,000	1,135,000	1,135,000	1,135,000	1,135,000	1,135,000	1,135,000	1,135,000	1,135,000	1,135,000	1,135,000	1,135,000	1,135,000
3	Уралдаан, тэмцээний зардал	9,420,000		2,100,000	2,220,000	4,700,000					400,000			
4	Нэг удаагийн шагнал, урамшуулал	8,000,000						8,000,000						
5	Бусад зардал	10,000,000	10,000,000											
6	Дүн	150,000,000	20,215,000	12,315,000	12,435,000	14,915,000	10,215,000	18,215,000	10,215,000	10,215,000	10,615,000	10,215,000	10,215,000	10,215,000


 2023 оны 01 дүгээр сарын 15-ний
 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

Аймгийн Засаг даргын
 Дүгээр сарын 15-ний
 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

